



ШУВУУНЫ ТОМУУ ӨВЧНИЙ ТОХИОЛДОЛ ТАРХАЛТЫН ХОЁР ДОЛОО ХОНОГ ТУТМЫН МЭДЭЭ №5

Нэг. Монгол оронд бүртгэгдсэн шувууны томуугийн сэжигтэй тохиолдол

2025 оны 02 сарын 25 наас 03 сарын 25 ны хооронд шувууны томуугийн холбогдолтой өвчлөлийн сэжигтэй тохиолдол бүртгэгдээгүй.

Хоёр. Дэлхий дахинд бүртгэгдсэн шувууны томуугийн хүний өвчлөл

2025 оны 02 сарын 25 наас 03 сарын 25 ны хооронд шувууны томуугийн А хүрээний H3N8, H3N2, H7N9, H6N1, H10N8, H7N4, H5N8, H9N2, H5N6, H10N3, H10N5 вирусийн хүний өвчлөлийн шинэ тохиолдол бүртгэгдээгүй байна.

Тохиолдол 1:

Камбожи улсын Прейвэнг мужид 02 сарын 25 ны өдөр шувууны томуугийн өндөр хоруу H5N1 өвчнөөр 2 настай хүүхэд нас барсан. Тухайн хүүхдийн гэр бүл 15 тахиатай байсан ба зарим шувууд өвчилсөн байсан. Прейвэнг мужид өмнөх 7 хоногт шувууны аж ахуйд өвчлөл бүртгэгдсэн байсан.

Тохиолдол 2:

Камбожи улсын Крэтэй мужид 3 настай хүүхэд шувууны томуу H5N1 өвчнөөр нас барсан ба 2025 он гарсанаар тухайн улсад бүртгэгдсэн 3 дахь тохиолдол болж байна. Хүүхдийн эцэг эх нь өвчилсөн тахиаг хүнсэндээ ашигласан гэж үзсэн.

Гурав. Дэлхий дахинд бүртгэгдсэн шувууны томуугийн А хүрээний вирусээр өвчилсөн амьтдын мэдээлэл:

2025 оны 02 сарын 25 наас 03 сарын 25 ны хооронд шувууны томуугийн А хүрээний вирус Албани, Австрали, АНУ, Бельги, Болгар, Камбожи, Канад, Чех, Дани, Их Британи, Вьетнам, Тайвань, Герман, Өмнөд Солонгос, ОХУ, Испани, Польш зэрэг 34 улс орны газар нутагт нүүдлийн болон тэжээвэр шувуудын дунд 349 тохиолдол бүртгэгдсэн. (хүснэгт 1, зураг 1)

Хүснэгт 1. Шувууны томуугийн А хүрээний вирусийн хэв шинжээр тархалт

Дэд хэвшинж	Улс	Зүйлийн нэр	Нийт тохиолдол
H5N1	Албани	Шувууны аж ахуй	2
H7N8	Австрали	Шувууны аж ахуй	1
H5N1	АНУ	Шувууны аж ахуй, үхэр, муур, гэрийн хулгана, далайн хав	103
H5N1	Бельги	Шилийн сар, хөх дэглий, үнэг, зэрлэг муур	8
H5N1	Болгар	Тахианы аж ахуй	1


H5N1	Камбожи	Тахианы аж ахуй, нүүдлийн шувуу, хүний өвчлөл	5
H5N1	Канад	Шувууны аж ахуй	4
H5N1	Чех	Шувууны аж ахуй, гунгар хун	6
H5N1	Дани	Шилийн сар, бор галуу, элээ, хун, цагаан сүүлт бүргэд	10
H5N1	Финланд	Харцага, галуу	2
H5N1	Франц	Цахлай, хун	9
H5N1	Герман	Хун, галуу, өрөвтас, цахлай	38
H5N1	Грек	Борцгор хотон	1
H5N1	Унгар	Шувууны аж ахуй, хун, шилийн сар	29
H5N1	Исланд	Гэрийн муур	4
H5N1	Ирланд	Шилийн сар, бор галуу, гангар хун	3
H5	Япон	Хэрээ	5
H5N1	Мексик	Галуу	1
H5N1	Молдав	Шувууны аж ахуй	1
H5	Нидерланд	Шилийн сар, зэрлэг нугас, цахлай бор галуу, гангар хун	20
H5	Перу	Шувууны аж ахуй	1
H5N1	Польш	Галуу, хун, шувууны аж ахуй	38
H5N1	Өмнөд Солонгос	Хун, галуу, цагаан дэглий, зэрлэг нугас, тахиа	11
H5N1	Румин	Шувууны аж ахуй, зэрлэг нугас	3
H5N1	Орос	Хон хэрээ	2
H5N1	Испани	Эгэл шонхор	1
H5N1	Швед	Хун, галуу, цууцал,	6
H5N1	Вьетнам	Нүүдлийн шувууд	2
H5N1	Тайвань	Шувууны аж ахуй	6
H5	Того	Тахианы аж ахуй	3
H5N1	Их Британи	Галуу, шонхор, сар, шувууны аж ахуй, хонь	25
H5N1	Украин	Шувууны аж ахуй	1

Ихэвчлэн шувууны аж ахуй, нүүдлийн шувууд болох галуу, нугас, тэжээвэр амьтад болох үхэр, муур зэрэг амьтдын дунд өвчлөл бүртгэгдсэн.

Англи улсын хойд Ёркширд мужид шувууны томуугийн H5N1 вирусийн халдвараар хонь өвчилсөн анхны тохиолдол бүртгэгдсэн. Одоогоор тус улсад амьтны эрүүл мэндийн байгууллагын хамтарсан тандалт судалгааг хийж, өвчилсөн хонийг төхөөрч дотоод эд эрхтний сорьц авсан ба шинжилгээ үргэлжилж байна.

Эх сурвалж: <https://empres-i.apps.fao.org/>

Зураг 1. 2025 оны 02 сарын 25 наас 03 сарын 25 ны хооронд шувуудын дунд бүртгэгдсэн шувууны томуугийн А хүрээний вирусийн тохиолдлын тархалт



НИЙГМИЙН ЭРҮҮЛ МЭНД, ТАНДАЛТ ШУУРХАЙ УДИРДЛАГЫН АЛБА